

6-р анги Түүх: Хүннү гүрэн

Ажлын хуудас

1. Нөхөж бичнэ үү.

Монголчууд бидний өвөг дээдэс бол юм.

Хүннү гүрнийг онд байгуулжээ.

Түүхэн тэмдэглэл:

НТӨ 209 онд Түмэн шаньюйн хүү Модунь Хүннүгийн шаньюй болов. Хүннү гүрэн хүчирхэгжин мандсан нь Модунь шаньюйн үйл ажиллагаатай шууд холбоотой. Модунь хүчирхэг Дунхуг эзэлсний дараа баруун талын Юэжи, Усунь, хойд талын Динлинг дайлан нэгтгэснээр Хүннү төв Азийн хүчирхэг гүрэн болсон билээ.

2. Хүннү гүрнийг хэрхэн хувааж захирсан бэ? (Бүдүүвчийг нөхөх эсвэл тайлбарлах)

Шаньюй		
Баруун гар (ван)	Төв хэсэг (Шаньюй)	Зүүн гар (ван)
Түмт	Түмт	Түмт
Мянгат	Мянгат	Мянгат
Зуут	Зуут	Зуут
Аравт	Аравт	Аравт

Бүдүүвч 5.1. Хүннүгийн төр, захиргааны зохион байгуулалт

3. Зөвийг сонгож нөхнө үү.

НТӨ 200 онд Модунь шаньюй өмнөд хөрш улс руу довтлов.

НТӨ онд Хүннү улс, Хан улс хоёр гэрээ байгуулжээ.

4. Аж ахуй ба амьдралын хэв маяг:

Хүннүчүүд эрхлэн, жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг байв. Мөн Орхон, Сэлэнгэ мөрний сав газраар эрхэлдэг байжээ.